



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар Зүүн Азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо ХК-ийн
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/58/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Бадамхатан Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ц.Наранцогт Утас: 325093 Цахим хаяг: narantsogtts@audit.gov.mn</p>
---------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 689

танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ЗҮҮН АЗИЙН
ЗАЛУУЧУУДЫН НААДАМ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХОРОО ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
П.БУЯНДЭЛГЭР ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар Зүүн азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улаанбаатар Зүүн азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулаагүй алдаа, зөрчил нь шинж чанарын хувьд бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд НББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Улаанбаатар зүүн азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо ХК нь Зүүн азийн залуучуудын спортын наадмыг 2023 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс 19-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, тэмцээн уралдааныг олон улсын стандартын дагуу зохион байгуулсан байна.

Улаанбаатар зүүн азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо ХК нь Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан төлөвлөгөөний дагуу Зүүн азийн залуучуудын спортын наадмыг хариуцан зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, техникийн шаардлагыг хангасан спортын хэрэглэл, тоног төхөөрөмж авах хөрөнгийг төвлөрүүлэн зохицуулах чиг үүргийг өөрийн дотоод эх үүсвэр болон бусад эх

D:\Desktop\2024\Word\Баам\2024.03.15\UB.ZAZAZB\орлоо.docx

002022249

үүсвэрээр санхүүжүүлэн хэрэгжүүлж үүрэг дуусгавар болмогц татан буугдах зохицуулалттай.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	83,627,368.77	776,652,952.37
1.1.2	Дансны авлага	30,280,000.00	28,518,804.32
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	275,424.87	
1.1.6	Бараа материал	3,659,050.00	686,641,560.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	453,673,602.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	117,841,843.64	1,945,486,918.69
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	365,227,055.58	463,279,277.91
1.2.2	Биет бус хөрөнгө	18,976,054.15	9,075,504.19
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	384,203,109.73	472,354,782.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	502,044,953.37	2,417,841,700.79
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр		106,723,539.90
2.1.1.1	Дансны өглөг		38,172,774.46
2.1.1.3	Татварын өр		68,550,765.44
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		106,723,539.90
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	502,044,953.37	2,311,118,160.89
	Өмч	-	-
2.3.1	Өмч: а) төрийн	-	-
2.3.2	б) хувийн	-	-
2.3.3	в) хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	80,000.00	80,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	501,964,953.37	2,311,038,160.89
2.3.11	Эздийн өмчийн дүн	502,044,953.37	2,311,118,160.89
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	502,044,953.37	2,417,841,700.79

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Борлуулалтын орлого (цэвэр)	1,784,570,000.00	16,778,503,000.00
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	1,784,570,000.00	16,778,503,000.00
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,100,892.00	121,884,801.15
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,283,705,938.63	13,335,193,107.98
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		1,730,320,255.28
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	501,964,953.37	1,834,874,437.89
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	501,964,953.37	1,834,874,437.89
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	501,964,953.37	1,834,874,437.89
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
210304	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү /гарз/	0.00	-25,740,702.11
2104	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	501,964,953.37	1,809,133,735.78
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	80,000.00	-	501,964,953.37	502,044,953.37
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,000.00	-	501,964,953.37	502,044,953.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(60,528.26)	(60,528.26)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,000.00	-	501,964,953.37	501,964,953.37
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	1,809,133,735.78	1,809,133,735.78
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,000.00	-	2,311,038,160.89	2,311,118,160.89

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,785,670,892.00	18,190,202,762.16
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,784,570,000.00	16,778,503,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,100,892.00	1,411,699,762.16
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,313,189,928.23	17,353,611,576.45
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	567,255,107.79	2,212,166,770.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	60,603,865.47	571,073,037.20
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	29,903,964.00	650,897,366.39
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	89,424,000.00	362,814,026.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		323,680,398.00
1.2.6	Татварын байгууллагад төлсөн		544,415,989.79
1.2.9	Бусад мөнгөн зарлага	566,002,990.97	12,688,563,988.85
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	83,551,018.31	836,591,185.71
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	388,933,595.00	117,824,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	388,933,595.00	117,824,900.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	388,933,595.00	(117,824,900.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	80,000.00	
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад орлого	80,000.00	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	80,000.00	
4	Валютын ханшийн зөрүү		(25,741,702.11)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	83,627,368.77	693,025,583.60
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	83,627,368.77
7	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	83,627,368.77	776,652,952.37

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	83,627,368.77	(83,627,368.77)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,778,503,000.00	6,195,513,835.32	582,989,164.68	91.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	6,778,503,000.00	6,195,513,835.32	582,989,164.68	91.4
210	Бараа, үйлчилгээний зардал	6,748,503,000.00	6,169,071,366.32	579,431,633.68	91.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,545,776,000.00	1,674,806,448.23	(129,030,448.23)	108.3
210101	Үндсэн цалин	850,800,000.00	850,800,000.00	-	100.0
210102	Нэмэгдэл	17,520,000.00	17,520,000.00	-	100.0
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	187,795,000.00	187,795,000.00	-	100.0
210104	Урамшуулал	50,000,000.00	50,000,000.00	-	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	439,661,000.00	568,691,448.23	(129,030,448.23)	129.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,222,000.00	175,057,712.66	18,164,287.34	90.6
210201	Тэтгэврийн даатгал	131,390,000.00	125,482,645.41	5,907,354.59	95.5
210202	Тэтгэмжийн даатгал	15,458,000.00	13,789,420.30	1,668,579.70	89.2
210203	ҮОМШӨ ний даатгал	12,366,000.00	11,798,599.73	567,400.27	95.4
210204	Ажилгүйдлийн даатгал	3,092,000.00	1,952,392.88	1,139,607.12	63.1
210205	Эрүүл мэндийн даатгал	30,916,000.00	22,034,654.34	8,881,345.66	71.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,240,000.00	196,469,526.00	(58,229,526.00)	142.1
210304	Байрны түрээс	138,240,000.00	196,469,526.00	(58,229,526.00)	142.1
2104	Хангамж, бараа материалын зардал	106,155,990.00	530,976,109.01	(424,820,119.01)	500.2
210401	Бичиг хэрэг	23,400,000.00	34,398,861.01	(10,998,861.01)	147.0
210402	Тээвэр (шатахуун)	60,335,990.00	305,370,418.00	(245,034,428.00)	506.1
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	22,420,000.00	20,554,610.00	1,865,390.00	91.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	170,652,220.00	(170,652,220.00)	0.0
2105	Нормативт зардал	39,060,400.00	-	39,060,400.00	0.0
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	21,060,400.00	-	21,060,400.00	0.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	18,000,000.00	-	18,000,000.00	0.0
2106	Эд хогшил худалдан авах	1,000,000.00	702,500.00	297,500.00	70.3
210604	Урсгал засвар	1,000,000.00	702,500.00	297,500.00	70.3
2107	Томилолт, зочны зардал	35,700,000.00	53,998,220.00	(18,288,220.00)	151.2
210701	Гадаад албан томилолт	35,700,000.00	53,988,220.00	(18,288,220.00)	151.2
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,659,348,610.00	3,514,341,975.42	1,145,006,634.58	75.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,638,748,610.00	3,494,603,975.42	1,144,144,634.58	75.3
210805	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	15,600,000.00	15,600,000.00	-	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	5,000,000.00	4,138,000.00	862,000.00	82.8
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	22,728,875.00	7,271,125.00	75.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.00	6,417,653.00	23,582,347.00	21.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	16,311,222.00	(16,311,222.00)	0.0
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,000,000.00	26,442,469.00	3,557,531.00	88.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,000,000.00	26,442,469.00	3,557,531.00	88.1
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	30,000,000.00	26,442,469.00	3,557,531.00	88.1
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,778,503,000.00	6,914,280,121.03	(135,777,121.03)	102.0

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,778,503,000.00	6,796,003,000.00	(17,500,000.00)	100.3
132001	Орон нутгийн төсвөөс	6,778,503,000.00	6,796,003,000.00	(17,500,000.00)	100.3
120004	БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	118,277,121.03	(118,277,121.03)	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	118,277,121.03	(118,277,121.03)	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	83,627,368.77	(83,627,368.77)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	776,652,952.37	(776,652,952.37)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30	23	7	76.7
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	25	18	7	72.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жолоочийн замын хуудсыг бүрэн хөтлөөгүй, шатахууны зарцуулалтын тооцоог холбогдох заавар, журмын дагуу тооцоогүй.	1	12,680.6					1	12,680.6
Онгоцны тийзийн тооцоог давхардуулан шилжүүлсэн.	1	45,414.3	1	45,414.3				
Албан тушаалын цалингаас гадна хамаарал бүхий этгээдээс гэрээний дагуу цалин авсан.	1	30,000.0					1	30,000.0
Хүлээн авалт, урлагийн зардал нэрээр үр ашиггүй зардал гаргасан.	1	62,526.4					1	62,526.4
Бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ ажлын гүйцэтгэл, хэрэгжилтийг хянажгүй шууд шилжүүлсэн.	1	-					1	-
Байгууллагын дотоод хяналт сул, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.	1	-					1	-
Иргэнтэй шууд гэрээ байгуулан төлбөрийг шилжүүлэхдээ давхардуулан шилжүүлсэн.	1	6,000.0	1	6,000.0				
Хэвлэлийн компаниар ширээний хуанли хэвлүүлж, төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	2,700.0					1	2,700.0
Оффисын ажилтнуудад спортын цол тэмдгийг нэмэгдэл цалин олгосон.	1	35,805.1					1	35,805.1
Дүн	9	195,126.4	2	51,414.3	-	-	7	143,712.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим мэдээллийн системд 3 мэдээллийг хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Дүн	1	-						
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Эйр тикет ХХК-аас нислэгийн тийз авахдаа шууд гэрээ байгуулан, худалдан авалт хийсэн.	1	475,226.3					1	475,226.3
Зар сурталчилгааг явуулахдаа сонгон шалгаруулалт хийгээгүй.	1	364,625.0					1	364,625.0
Спортын наадмын тоног төхөөрөмж, спортын хувцсыг сонгон шалгаруулалтгүй, шууд худалдан авсан.	1	1,920,445.8					1	1,920,445.8
Тамирчид, шүүгч, бусад албаны хүмүүсийг тээвэрлэх зорилгоор сонгон шалгаруулалтгүй, шууд гэрээ байгуулан, ажил гүйцэтгүүлсэн.	1	350,475.0					1	350,475.0
Тохижилтын ажилд шууд гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн.	1	650,000.0					1	650,000.0
Дүн	5	3,760,772.1					5	3,760,772.1
Нийт дүн	6	3,760,772.1					6	3,760,772.1